



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/188/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: tcc.audit.mn@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1 Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	16
4.2 Зөвлөмж.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУЯам	Боловсрол шинжлэх ухааны яам
ДЗОУБ	Дэлхийн зөн олон улсын байгууллага
ГБХЗХГ	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ХАОНӨГ	Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/2022
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН "АВЬЯАС" СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Г.АНХТУЯА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын "Авьяас" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын "Авьяас" сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудитын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	217,836,055.05	263,342,255.41
35	БАРАА МАТЕРИАЛ	217,836,055.05	263,342,255.41
351	Түүхий эд материал	1,444,546.00	5,318,281.00
35130	Эм боох материал	1,444,546.00	5,318,281.00
354	Хангамжийн материал	216,391,509.05	258,023,974.41
35410	Бичиг хэргийн материал	2,861,910.00	2,787,580.00
35420	Аж ахуйн материал	1,045,440.00	784,150.00
35440	Түлш, шатах тослох материал	384,000.00	00.00
35450	Барилгын засварын материал	1,938,110.00	2,300,200.00
35470	Бусад хангамжийн материал	210,162,049.05	252,152,044.41
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	424,237,206.09	502,013,100.45
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	424,237,206.09	502,013,100.45
392	Биет хөрөнгө	176,752,316.76	255,560,922.40
39201	Барилга, байгууламж, орон сууц	312,905,165.15	312,905,165.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	-266,515,742.51	-270,125,157.35
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	152,867,255.15	144,024,601.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	-97,975,786.16	-21,759,367.39
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	61,105,548.00	87,303,700.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,597,127.90	-31,365,445.76
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,695,887.00	6,801,297.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,445,354.50	-4,006,711.88
39217	Ном	35,712,472.53	31,782,840.80
393	Биет бус хөрөнгө	247,484,889.33	246,452,178.05
39301	Програм хангамж	10,608,556.00	10,773,556.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-856,166.67	-2,053,877.95
39303	Бусад биет бус хөрөнгө	237,732,500.00	237,732,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	642,073,261.14	765,355,355.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	642,073,261.14	765,355,355.86
51	Засгийн газрын хувь оролцоо	642,073,261.14	765,355,355.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	641,784,144.72	641,784,144.72
51101	Өмч: - төрийн	641,784,144.72	641,784,144.72
512	Хуримтлагдсан үр дүн	-44,877,393.18	78,404,701.54
51210	Өмнөх үеийн үр дүн	-44,877,393.18	-44,877,393.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	123,282,094.72
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	45,166,509.60	45,166,509.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	642,073,261.14	765,355,355.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,269,808,418.25	1,318,266,915.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,174,953,783.25	1,183,417,876.09
120	Нийтлэг татварын бус орлого	13,023,383.25	88,525,476.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13,023,383.25	88,525,476.09
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	13,023,383.25	88,525,476.09
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,161,930,400.00	1,094,892,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,161,930,400.00	1,094,892,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,854,635.00	134,849,038.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,536,735.00	19,111,038.91

131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,431,700.00	17,626,038.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,035.00	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	92,317,900.00	115,738,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,317,900.00	115,738,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,166,829,082.22	1,181,656,681.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,166,829,082.22	1,181,656,681.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,133,546,219.22	1,134,470,560.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,019,366.00	837,959,712.36
210101	Үндсэн цалин	797,017,624.00	632,144,099.76
210102	Нэмэгдэл	00.00	156,741,824.60
210104	Урамшуулал	69,001,742.00	49,073,788.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,552,073.00	111,996,485.39
210201	Тэтгэврийн даатгал	75,384,464.00	78,478,430.05
210202	Тэтгэмжийн даатгал	8,788,284.00	8,432,756.55
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,939,390.00	6,714,371.87
210204	Ажилгүйдлийн даатгал	1,684,604.00	1,670,084.46
210205	Эрүүл мэндийн даатгал	17,755,331.00	16,700,842.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,082,079.00	86,080,789.73
210301	Гэрэл, цахилгаан	2,598,651.00	2,857,520.00
210302	Түлш, халаалт	76,283,428.00	78,592,111.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,631,158.73
2104	Хангамж, бараа материалын зардал	22,475,613.00	14,389,269.00
210401	Бичиг хэрэг	1,318,300.00	3,343,635.00
210402	Тээвэр, шатахуун	2,614,760.00	598,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	173,900.00	359,992.00
210404	Ном, хэвлэл	2,602,600.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,132,045.00	2,644,788.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,755,508.00	2,561,540.00
210408	Бараа материал акталсны зардал	2,878,500.00	4,881,314.00
2105	Нормативт зардал	611,892.00	907,448.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	611,892.00	907,448.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,337,160.00	34,762,510.00
210604	Урсгал засвар	8,337,160.00	34,762,510.00
2107	Томилот, зочны зардал	764,400.00	80,000.00
210702	Дотоод албан томилот	764,400.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,924,315.00	5,990,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,324,315.00	5,270,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,779,321.22	42,303,546.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,360,950.00	14,087,771.25
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	28,418,371.22	28,215,774.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,282,863.00	47,186,121.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,165,000.00	41,299,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,045,000.00	37,768,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,120,000.00	3,530,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	405,321.00	198,961.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	405,321.00	196,810.27
213404	Хөрөнгийн	00.00	2,150.91

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,712,542.00	5,687,760.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,712,542.00	5,687,760.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	102,979,336.03	136,610,233.09
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	13,328,138.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	13,328,138.37
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-13,328,138.37
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	102,979,336.03	123,282,094.72

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,784,144.72	-147,856,729.21	539,093,925.11
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	641,784,144.72	-147,856,729.21	539,093,925.11
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	102,979,336.03	102,979,336.03
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,784,144.72	-44,877,393.18	642,073,261.14
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,784,144.72	-44,877,393.18	642,073,261.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	641,784,144.72	-44,877,393.18	642,073,261.14
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	123,282,094.72	123,282,094.72
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	641,784,144.72	78,404,701.54	765,355,355.86

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,256,785,035.00	1,229,741,438.91
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,161,930,400.00	1,094,892,400.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	1,161,930,400.00	1,094,892,400.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	1,161,930,400.00	1,094,892,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	94,854,635.00	134,849,038.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,536,735.00	19,111,038.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,431,700.00	17,626,038.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,035.00	35,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	92,317,900.00	115,738,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	92,317,900.00	115,738,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,186,171,713.00	1,179,537,638.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,186,171,713.00	1,179,537,638.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,152,888,850.00	1,132,351,517.48

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,019,366.00	837,959,712.36
210101	Үндсэн цалин	661,863,895.00	581,981,922.80
210102	Нэмэгдэл	135,153,671.00	206,653,048.56
210104	Урамшуулал	69,001,800.00	49,324,741.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,552,073.00	111,996,485.39
210201	Тэтгэврийн даатгал	77,353,073.00	78,948,128.07
210202	Тэтгэмжийн даатгал	8,199,500.00	8,262,077.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,597,900.00	6,609,651.45
210204	Ажилгүйдлийн даатгал	1,644,100.00	1,652,425.63
210205	Эрүүл мэндийн даатгал	16,757,500.00	16,524,203.16
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,082,079.00	86,080,789.73
210301	Гэрэл, цахилгаан	2,598,651.00	2,857,520.00
210302	Түлш, халаалт	76,283,428.00	78,592,111.00
210303	Цэвэр, бохир ус	4,200,000.00	4,631,158.73
2104	Хангамж, бараа материалын зардал	20,583,840.00	28,458,630.00
210401	Бичиг хэрэг	818,935.00	3,046,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,998,760.00	214,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	173,900.00	359,992.00
210404	Ном, хэвлэл	2,602,600.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,132,045.00	3,223,888.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,857,600.00	21,614,750.00
2105	Нормативт зардал	4,611,275.00	989,400.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,611,275.00	989,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,279,502.00	31,460,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	25,449,002.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	8,830,500.00	29,460,400.00
2107	Томилолт, зочны зардал	764,400.00	80,000.00
210702	Дотоод албан томилолт	764,400.00	80,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,199,315.00	8,763,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,599,315.00	8,043,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,797,000.00	26,562,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	2,750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	29,797,000.00	23,812,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,282,863.00	47,186,121.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,165,000.00	41,299,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,045,000.00	37,768,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,120,000.00	3,530,600.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	405,321.00	198,961.18
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	405,321.00	196,810.27
213404	Хөрөнгийн	00.00	2,150.91
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,712,542.00	5,687,760.25
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,712,542.00	5,687,760.25
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	70,613,322.00	50,203,800.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	70,613,322.00	50,203,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,613,322.00	50,203,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	70,613,322.00	50,203,800.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	70,613,322.00	50,203,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-70,613,322.00	-50,203,800.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,210,630,400.0	1,204,745,829.5	5,884,570.5	99.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,210,630,400.0	1,204,745,829.5	5,884,570.5	99.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,168,014,000.0	1,163,696,429.5	4,317,570.5	99.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	840,595,200.0	837,959,712.4	2,635,487.6	99.7
210101	Үндсэн цалин	582,853,500.0	581,981,922.8	871,577.2	99.9
210102	Нэмэгдэл	208,411,700.0	206,653,048.6	1,758,651.4	99.2
210104	Урамшуулал	49,330,000.0	49,324,741.0	5,259.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	113,480,200.0	111,996,485.4	1,483,714.6	98.7
210201	Тэтгэврийн даатгал	79,856,500.0	78,948,128.1	908,371.9	98.9
210202	Тэтгэмжийн даатгал	8,405,900.0	8,262,077.1	143,822.9	98.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,724,700.0	6,609,651.5	115,048.6	98.3
210204	Ажилгүйдлийн даатгал	1,681,200.0	1,652,425.6	28,774.4	98.3
210205	Эрүүл мэндийн даатгал	16,811,900.0	16,524,203.2	287,696.8	98.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,277,600.0	86,080,789.7	196,810.3	99.8
210301	Гэрэл, цахилгаан	2,925,300.0	2,857,520.0	67,780.0	97.7
210302	Түлш, халаалт	78,752,300.0	78,592,111.0	160,189.0	99.8
210303	Цэвэр, бохир ус	4,600,000.0	4,631,158.7	-31,158.7	100.7
2104	Хангамж, бараа материалын зардал	25,252,700.0	25,251,242.0	1,458.0	100.0
210401	Бичиг хэрэг	568,100.0	568,000.0	100.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	214,000.0	214,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360,000.0	359,992.0	08.0	100.0
210404	Ном, хэвлэл	473,400.0	473,600.0	-200.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,992,300.0	2,990,900.0	1,400.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	20,644,900.0	20,644,750.0	150.0	100.0
2105	Нормативт зардал	989,400.0	989,400.0	00.0	100.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	989,400.0	989,400.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	68,720,400.0	68,720,400.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.0	19,500,000.0	00.0	100.0

210602	Тавилга	19,760,000.0	19,760,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	29,460,400.0	29,460,400.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	80,000.0	80,000.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	80,000.0	80,000.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,830,900.0	1,830,800.0	100.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,110,900.0	1,110,800.0	100.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0	00.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,787,600.0	30,787,600.0	00.0	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,787,600.0	30,787,600.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	42,616,400.0	41,049,400.0	1,567,000.0	96.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	42,616,400.0	41,049,400.0	1,567,000.0	96.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	39,335,800.0	37,768,800.0	1,567,000.0	96.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,280,600.0	3,280,600.0	00.0	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,210,630,400.0	1,204,745,829.5	5,884,570.5	99.5
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	115,738,000.0	115,541,189.7	196,810.3	99.8
132001	Орон нутгийн төсвөөс	115,738,000.0	115,541,189.7	196,810.3	99.8
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	1,094,892,400.00	1,089,204,639.75	5,687,760.3	99.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	71.00	71.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	56.00	56.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	14.00	14.00	00.0	100.0
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	664.00	746.00	-82.0	112.3
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	664.00	746.00	-82.0	112.3
630001	Төрийн өмчит ЕБС	664.00	746.00	-82.0	112.3

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,111,038.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,111,038.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,858,888.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,680,988.00
210401	Бичиг хэрэг	2,478,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	232,988.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	970,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,927,900.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,927,900.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,250,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,750,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	250,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	250,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	250,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,150.91
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,111,038.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,111,038.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,450,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,626,038.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	35,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төгс суурь стандарт аудит ХХК-ийн ахлах аудитор Д.Алтайбаяр, гүйцэтгэх захирал Т.Батсайхан, чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны хяналтыг хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төгс суурьт стандарт аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 09 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Багшийн чиглүүлэг, эцэг эхийн оролцоотойгоор сурагчдын хоцрогдлыг нөхөн бууруулж, бие даан сурах арга барилд дэмжлэг үзүүлэн хөгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2021 оны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

1. Хосолсон сургалтын хэлбэрийг амжилттай хэрэгжүүлэх
2. Оношлох үнэлгээг хийж, гарааг тогтоож, суралцагчдын сурлагын амжилтыг ахиулах
3. Багш, сурагч, эцэг эх, ажилчид хоорондоо хамтран ажиллах сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх
4. “Авьяасын хөтөч” дасгал ажлын дэвтрээр сурагчдыг өөрийн удирдлагатай суралцах арга барилд чиглүүлэх

5. Багш ажилчдын цахим орчинд ажиллах чадварыг сайжруулах
6. Багш нарын нэгдэл болон мэргэжлийн хэсгээрээ хамтран ажиллах нөхцөл боломжийг бий болгон дэмжих
7. Ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжааг эртнээс зөв олгох, чиглүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ болох "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.
- Монгол улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1500 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургууль 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 1.5 хувиар буюу 17.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 123.3 сая төгрөгөөр буюу 19.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1.

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	217.84	263.34	45.51
Үндсэн хөрөнгө	424.24	502.01	77.78
Биет бус хөрөнгө	247.48	246.45	-1.03
Нийт хөрөнгө	642.07	765.36	123.28
Хуримтлагдсан үр дүн	-44.88	78.40	123.28
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	642.07	765.36	123.28

Мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн данс нь оны эцэст үлдэгдэл байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 263.4 сая төгрөг болж 45.5 сая төгрөгөөр өссөн нь хандиваар 9.4 сая төгрөг, төсвийн хөрөнгөөр 85.2 сая төгрөг, дээд шатны байгууллагаас 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг эрх шилжүүлэн хүлээн авсан байна.

Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 77.8 сая төгрөгөөр өссөн нь:

- Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 50.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, БШУЯ-аас эрх шилжин 29.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаж авсан.
- Аймгийн ИТХ-ын 2021 оны №111 дүгээр тогтоолоор 40.2 сая төгрөгийн үлдэх өртөггүй үндсэн хөрөнгийг үнэлж орлого болгосонтой холбоотой байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 1.0 сая төгрөгөөр буурсан нь: Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0.8 сая төгрөгийн программ хангамжийг данснаас хассантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 78.4 сая төгрөг болж өмнөх оноос 123.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 14.8 сая төгрөгөөр буюу 1.2 хувиар өссөн байна. Үүнд:

- Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн зардал, тогтвортой хөгжил 2 төслийн хүрээнд ажиллаж байгаа сэтгэл зүйч 1, бага боловсролын хоцрогдол арилгахад дэмжигч багш 1 орон тоог нэмж ажилласан.
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дүгээр тогтоолоор урсгал засварын зардал 8.0 сая төгрөгөөр спорт заалны дээврийн засвар хийхэд
- Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 02 дугаар тогтоолоор өмнөх оны үлдэгдлээс 9.5 сая төгрөгөөр заалны цонх, хичээлийн байрны сангийн засвар хийсэн байна.
- Аймгийн Засаг даргын 2021 оны А/608 захирамжаар 6.9 сая төгрөгийг хичээлийн байрны шал засахад нийт 24.4 сая төгрөгийг зарцуулснаас шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,289.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж Боловсролын газарт хүргүүлсэн. Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 236.9 сая төгрөгөөр бууруулж улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 1,053.02 сая төгрөгөөр баталсан ба 5.9 сая төгрөгийг улсын нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Батлагдсан төвийг төсвийн саналтай харьцуулан хянахад үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, бохир усны зардал, эд хогшил худалдан авах, хичээл үйлдвэрлэлийн зардал, урсгал засварын зардлуудыг тус тус бууруулж, тодотголоор үр дүнгийн урамшуулал, эд хогшил худалдан авах, хичээл үйлдвэрлэл, урсгал засварын зардлыг 157.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь төсвийг үндэслэлтэй боловсруулахгүй байгааг харуулж байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,210.6 сая төгрөгийн төсөв батлагдсан. Үүнд:

- Сангийн сайдын 73 дугаар тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/608 дугаар захирамжаар 60.0 сая төгрөгийн төсвийн зохицуулалт хийсэн.
- Аймгийн ИТХ-ын 2021 оны №01 тогтоолоор тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих 80.1 сая төгрөг, орон нутгийн төсвөөс санхүүжих 8.0 сая төгрөг.
- Мөрөн сумын 2021 оны 02 тогтоолоор орон нутгийн төсвөөс санхүүжих 9.5 сая төгрөг нэмэгдсэн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1094.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 115.7 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч 1,204.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 5.9 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургууль нь дараах хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

Хөтөлбөр: 71802 Ерөнхий боловсрол

Зориулалт арга хэмжээ: 81834 –Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх
81835 – Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах
80109 – ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал
81801 – Үдийн цай хөтөлбөр
80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал

Хөтөлбөр арга хэмжээний зардлыг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 2

/сая.төгрөг/

Хөтөлбөр	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
81834	Боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө хөтөлбөр хэрэгжүүлэх	808.10	807.96	0.14	99.98
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	244.17	240.19	3.98	98.37
80109	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	115.74	115.54	0.2	99.83
81801	Үдийн цай хөтөлбөр	39.34	37.77	1.57	96.01
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	3.28	3.28		100

Нийт хөтөлбөрийн биелэлтийг 93.7 хувиар үнэлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийг хөтөлбөр тус бүрээр харуулав

Хүснэгт 3

/сая.төгрөг/

№	Орлого			Зарлага	Үлдэгдэл	Төвлөр үүлсэн
	Байгууллага	Зориулалт	Дүн			
1	“Тогтвортой хөгжил 2” төсөл	Ирээдүйгээ золиослохгүйгээр хамтдаа хөгжье	7.50	7.50	0.0	0.0
2	Боловсролын газар	Ариутгал, халдваргүйжүүлэл	0.23	0.23	0.0	0.0
3	Аймгийн ЗДТГ	Халдваргүйжүүлэлт	1.3	1.3	0.0	0.0
4	Мөрөн сум ЗД нөөц	Халдваргүйжүүлэлт	1.45	1.45	0.0	0.0
5	Боловсролын үнэлгээний төв	Боловсролын чанарын шинэчлэл	8.00	7.99	0.01	0.01
6	Боловсролын үнэлгээний төв	Үнэлгээ тогтоох бичиг хэргийн зардал	0.34	0.34	0.0	0.0
7	ГБХЗХГазрын	“Хүрэхүйн” хөтөлбөр	0.25	0.25	0.0	0.0
8	ХАОНӨГазар	Нэмэлт орлого	0.035	0.035	0.0	0.0
		ДҮН	19.11	19.11	0.01	0.0

Авьяас сургуулийн 2021 оны нэмэлт санхүүжилтийн дансны төсөв нийт 19.1 сая төгрөг, 2021 оны тендерийн орлого болох 0.035 сая төгрөг, ГБХЗХГ-ын “Хүрэхүй” хөтөлбөрийн шагналын 0.25 сая төгрөг, “Тогтвортой хөгжил 2” төслийн хүрээн дэх “Ирээдүйгээ золиослохгүйгээр хамтдаа хөгжье” төсөл санхүүжилт 7.5 сая төгрөг, Боловсролын газраас хуваарилсан ариутгал халдваргүйжүүлэлт хийлгүүлэх зардал 0.23 сая төгрөг, АЗДТГ-аас хуваарилсан 0.13 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Засаг даргын нөөцөөс хуваарилсан 1.45 сая төгрөг, Боловсролын чанарын шинэчлэлийн төсөл 8.0 сая төгрөг, Боловсролын үнэлгээний багийн үнэлгээ тогтоох бичиг хэргийн материалын үнэ 0.3 сая төгрөг тус тус орлогоор орж 19.1 сая төгрөг зориулалтын дагуу зарцуулагдаж 0.002 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

- Корона вирус цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан.
- Улсын болон орон нутгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосны улмаас сургалтын хэвийн үйл ажиллагаа хязгаарлагдаж байсан

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Төсөв санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Боловсролын газар нь батлагдсан төсвийг тайлбар тодруулга авахгүй төсвийг үндэслэлгүй хасаж төрийн сангийн системд оруулж байгааг цаашид анхаарах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын Авьяас сургууль www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 1.732.9 сая төгрөгийн 127 мэдээллээс 1,719.6 сая төгрөгийн 127 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Аудитаар Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- Үдийн хоолны норматив тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2021 оны 237 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны нормативд зардлыг хэтрүүлээгүй нь уг тогтоолын холбогдох заалттай нийцсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл тайлагнал, шилэн дансны мэдээлэлттэй холбоотой 0.3 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дахин шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Боловсролын газар нь төсвийн саналыг харгалзалгүйгээр бууруулан баталсан хэвээр байна.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын газар нь батлагдсан төсвийг төсвийн шууд захирагчийн санал санаачилгагүйгээр 79.3 сая төгрөгөөр бууруулан баталсан нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.11.1 дахь заалт “Төсвийн тогтвортой байдлыг хангасан байх”, Засгийн газрын 2018 оны 134 тоот тушаал” “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам” -ын 3.2 дахь заалттай бүрэн нийцэхгүй байна. Иймд Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийг бууруулан баталсан шалтгааныг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал илрээгүй тул залруулга хийгдээгүй болно.

4.2 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.